



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны
хээ)-ийг устгах үйл ажиллагааг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 12 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний “Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ыг Монгол Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 13 дугаар захирамжаар “Дээрх хуулиудын бэлтгэл ажлыг хангаж, хуульд заасан холбогдох журмын төслийг боловсруулах, ажлын хэсгээс хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г, 15 дугаар захирамжаар “Биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн удирдамж”-ийг тус тус баталсан.

Ерөнхий сайдын захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах үйл ажиллагааг яаралтай зохион байгуулахыг ДААЛГАХ нь:

Нэг. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт:

1.1 Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын хуулиар зөвшөөрснөөс бусад аргаар цуглуулсан, хадгалсан (олж авсан, бүрдүүлсэн, бүртгэсэн зэрэг) биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийн мэдээллийг устгах арга хэмжээг 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх;

1.2 Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасны дагуу 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн байгууллагад хадгалагдаж буй биеийн давхцахгүй өгөгдлийг ашиглах үйл ажиллагааг зогсоох;

1.3 Хэрэглэгчийн хурууны хээ уншигч төхөөрөмжүүд болон дуудаж ажилладаг сервисүүдийг зогсоох;

1.4 Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулиар ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтныг таньж, баталгаажуулах үйлдлийг хялбарчлах

143220017

зорилгоор ажилтны зөвшөөрлөөр биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-өөс бусад биометрик мэдээллийг ашиглаж болох ба цаг бүртгэлийн төхөөрөмжид хадгалагдсан хурууны хээний мэдээллийн санг устгах нүүр царай таних боломжтой төхөөрөмжтэй бол тохиргоог идэвхжүүлэх, уг төхөөрөмж байхгүй бол шинээр суурилуулах эсвэл хуулиар зөвшөөрсөн бусад аргаар ажилтныг таньж, баталгаажуулах;

1.5 Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй тохиолдолд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэх талаар сэрэмжлүүлж ажиллах.

Хоёр. Албан даалгаврын биелэлтийг тайлагнах чиглэлээр:

2.1 Мэдээлэл хариуцагч нь биеийн давхцахгүй өгөгдлийг цуглуулахад үндэслэл болгосон дүрэм, журам болон бусад эрх зүйн актуудыг хууль тогтоомжид нийцүүлж тайланд тусгаж ирүүлэх (хүчингүй болгосон, өөрчлөлт оруулсан тоон мэдээлэл);


2.2 Гарын хурууны хээ ашиглаж байгаа систем тоног төхөөрөмжийн техникийн мэдээлэл болон агуулж байгаа файл, өгөгдлийн баазыг устгаж, хавсралт хүснэгтийн дагуу холбогдох мэдээллийг нэгтгэн ирүүлэх;

2.3 Гарын хурууны хээний цуглуулсан болон хадгалсан мэдээллийг устгасан талаар тайлан мэдээ гаргаж ирүүлэх.

Гурав. Дээр дурдсан ажлыг яаралтай зохион байгуулж, албан даалгаврын хэрэгжилтийг 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн дотор Эрүүл мэндийн яаманд ирүүлэхийг үүрэг болгосугай.

Дөрөв. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ц.Эрдэмбилэг)-д даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

